



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 37

Номгон

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн
албан татвар, орон нутгийн зам ашигласны хураамж
хураалтын тогтолцоог шинэчлэн хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр 64.1, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны төлбөр, хураамжийг хураах ажлыг тухайн оны 06 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны хураамжийг улсын дугаарын сүүлийн оронгийн тоогоор төлөх дарааллыг дараах байдлаар тогтоосугай.

- 1, 6 тоогоор төгссөн бол нэгдүгээр сард
- 2, 7 тоогоор төгссөн бол хоёрдугаар сард
- 3, 8 тоогоор төгссөн бол гуравдугаар сард
- 4, 9 тоогоор төгссөн бол дөрөвдүгээр сард
- 5, 0 тоогоор төгссөн бол тавдугаар сард тус тус хамрагдана.

3. Дээрх шаардлагыг хангаагүй авто тээврийн хэрэгслийг техник хяналтын үзлэгт хамруулахгүй, авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар арга хэмжээ авч хамтран ажиллахыг Баянхонгор аймаг дахь Авто тээврийн төв /С.Амармөнх/, Цагдаагийн газар /Ц.Анхбаяр/-т тус тус үүрэг болгож, Татварын хэлтэстэй хамтран ажиллахыг даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР